

Өөрийн
жаргалыг
урьтал болгох

D.Urantsetseg@must.edu.mn

ГЭР БҮЛИЙН АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛЫН ХАМГИЙН ЭНГИЙН ТҮЛХҮҮР БОЛ ХОСУУД ҮГЛЭЖ ЯНШИХААС ЗАЙЛСХИЙХ ХЭРЭГТЭЙ.

◆ Францийн эзэн хаан гуравдугаар Напалеон хорвоогийн хамгийн сайхан бүсгүй Тебий гүнж Мери Эженид хайртай болсон. Хааны зөвлөхүүд хориглосон боловч тэрээр “Би хайртай хүүхнээ хэнээс ч илүүд үзнэ” гээд гэрлэсэн байдаг. Гэвч удалгүй хайр нь хөрч, дурлалын гал нь бөхсөн байдаг. Учир нь Эжен хатан хаан болсон хэдий ч олиггүй хэрүүлч яншаа зантай байжээ. Тэрээр хааныг цаг үргэлж хардаж, хэрүүл өдөөн, бүр төрийн хэргээ явуулж байхад нь хүртэл тасалгаанд нь орж хэрүүл хийж, хардаж тараадаг байжээ. Эцэсийн эцэст хаан ордондоо тайван амар, цор ганцаар байх нам гүм булан олдохоо больж, шөнө ордноос нууцаар оргон зайлж өөр гоо бүсгүйтэй болздог байжээ.

ХАНЬ ИЖЛЭЭ ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ БИШРЭН ХҮНДЭТГЭЖ, МАГТАН САЙШААЖ БАЙХ ХЭРЭГТЭЙ

◆ Нэг эмэгтэй нөхрөө ажлаас тараад, ядраад ирэхэд үргэлж сайхан амттай хоол бэлтгэдэг байжээ. Нөхөр нь эхнэрээ ямар их сэтгэл гаргасныг тоодоггүй байсан тул эхнэр нь нэг өдөр ажлаасаа ирэхэд тавганд нь өвс овоолоод өгсөн гэнэ. Гэтэл нөхөр нь уурлаад арай солиорчхоогүй гэнэ. Эхнэр нь чамайг анзаарах юм гэж яаж мэдэх вэ? Хорин жил та нарт хоол бэлтгэж хийхдээ “Хөөрхийлөх” үг нэгийг ч сонссонгүй шүү гэж хэлсэн байдаг.

**ЭР ХҮН АЖИЛ ҮЙЛСДЭЭ АМЖИЛТ ОЛОХЫН ТУЛД ЮУГАА Ч
ХАЙРЛАХГҮЙ ЗҮТГЭДЭГ ШИГЭЭ ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД
АНХААРЧ ЧАДДАГГҮЙ.**

◆ Оросын суут зохиолч И.С. Тургенев “Хоолоо хөрчихөөс нь өмнө идчихээсэй гэж үнэхээр өөрт нь санаа тавьдаг эмэгтэйтээ хаа нэгтээ тааралдсан бол авьяас билэг, бүх номоо оронд нь өгөх байсан” гэж хэлсэн байдаг.

ГЭР БҮЛИЙН ХУУЛЬ

- ◆ 10.1.Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.
- ◆ 10.2.Гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт эд хөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах тэгш эрхтэй.
- ◆ 10.3.Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээнэ.

Гэр бүлийн аз жаргал



Хувийн аз жаргал



<https://www.youtube.com/watch?v=X7BU1gWcDa8>

◆ Б.МАГСАРЖАВ

ХИЛИЙН ЗАСТАВЫН ХАР НҮДЭН БҮСГҮЙ

<http://ub.life/p/http-ub-life-articles-edit-23572>

- ◆ “Гунихын урьтал, баярлахын шалтгаан юм” гэсэн. “Амьдралын хором мөч бүрийг нэгэн хэмнэлээр мэдэрдэг бол хэчнээн уйтгартайв. Зовлон, жаргал ээлжилдэг нь яасан сайхан үнэн бэ. Гунихын урьтал, баярлахын шалтгаан бүрэлдэн бий болж буй учир нь үл ойлгогдох долгисыг мэдэрч тайлах нь миний амьдрал, миний хөгжим юм шиг байна”.
- ◆ Ардын уран зохиолч П.Бадарчийн “Анхны бороо”, Б.Лхагвасүрэнгийн “Зүүдэн бороо”, “Янзага”, “Эр хүнийг хайрлаж яваарай”, Ш.Сүрэнжавын “Тэсийн голын унага”, Д.Цоодолын “Ээждээ”, “Сүслэн хайрлаж яваарай”, Ш.Дулмаагийн “Хилийн заставын хар нүдэн бүсгүй”

Гэр бүлдээ захидал бичээрэй

◆ БЭЛТГЭХ ЗҮЙЛ

-Дугтуй

-А4 цаас

-Цавуу

-Гэр бүлийн зураг